

Ханой, Халонг Бай, Дананг, Хой Ан 4 хотын аяллын хөтөлбөр 7 шөнө 8 өдөр

Өдөр	Товч Хөтөлбөр	Хоол
Өдөр 1	Улаанбаатар – Ханой нислэг	Оройн хоол
Өдөр 2	Ханой - Халонг Бай , Круиз аялал	Өглөөний цай, өдөр, оройн хоол
Өдөр 3	Халонг чөлөөт өдөр	Өглөөний цай
Өдөр 4	Халонг – Ханой - Дананг нислэг	Өглөөний цай, оройн хоол
Өдөр 5	Дананг – Банна Хиллс	Өглөөний цай, өдрийн хоол
Өдөр 6	Дананг хотын аялал	Өглөөний цай
Өдөр 7	Дананг чөлөөт өдөр	Өглөөний цай
Өдөр 8	Дананг - Ханой – Улаанбаатар нислэг	Өглөөний цай

ӨДӨР 1: УЛААНБААТАР- ХАНОЙ

08:00-12:00 Улаанбаатар – ХАНОЙ шууд ниснэ. Нислэг эхлэхээс 3 цагийн өмнө бүртгэл нээгдэх тул ОУ нисэх буудал дээр цугларан аяллын групптэй нэгдэнэ. Вьетнам улсын Ханой хотын нисэх буудалд буун хил гаалиар гаран ачаа тээшээ авна. Хөтөч та бүгдийг угтан авч зочид буудалд хүргэж өгнө. Өрөөгөө хүлээн авсны дараа хэсэг амраад оройн хоолтой.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье

ӨДӨР 2: ХАНОЙ - ХАЛОНГ БЭЙ - КРУЙЗ АЯЛАЛ

Өглөөний цайны дараа Ханой хотоос хөдөлж, Улаан голын хөндий дагуух ногоон төгөл, үзэсгэлэнт байгальтай Халонг хот руу аяллаа эхлүүлнэ. Халонг нь Вьетнам улсын нийслэл Ханойгоос зүүн хойш 170 км зайд орших, аялал жуулчлалын онцгой бүс, ЮНЕСКО-ийн Дэлхийн Соёлын өвд албан ёсоор бүртгэгдсэн, байгалийн үзэсгэлэн төгс цогцолсон, алдартай газар юм.

Сэтгэлийг тань баясгаж, хараа булаам байгалийн санаанд оромгүй тогтоц бүхий, том жижиг 1969 ширхэг хадан цохио бүхий арлуудаас Халонг булан нь бүрддэг. Газар дээрх болон усан доорх био ертөнцийн зохицол болох Халонг булан нь 1500 мв.км талбайг эзэлнэ. Халонг хэмээх үг нь “Луу далайд бууж заларсан газар” гэсэн утгаар орчуулагддаг байна.


Халонгт хүрэлцэн ирмэгц, нутгийн онцлог амтыг мэдрүүлсэн далайн хоолыг орон нутгийн ресторанд зооглоно. Туан Чау боомт руу очин 5–6 цаг үргэлжлэх завин аялалдаа гарна. Завин дээр далайн хоол идэж, өвөрмөц хэлбэртэй арал, хаднуудыг үзнэ. Эхлээд “Гайхамшигт агуй”-г үзэж, сонирхолтой хэлбэртэй чулуу, тогтоцтой танилцана. Дараа нь Титоп аралд очиж, цагаан элстэй эрэг дээр амарч, оргилд нь гарч Халонг булангийн гайхалтай байгалийг харна. Луон агуйд очиж, завиар эсвэл бамбу завиар сэлж, үзэсгэлэнт нуур, тайван байгальтай танилцана. Энэ өдөр круйз дээрээ хононо.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

ӨДӨР 3: ХА ЛОНГ БАЙ - ХАНОЙ - ДАНАНГ

Өглөөний цайны дараа төрөл бүрийн сонирхолтой хөтөлбөрт хамрагдах болно. Өдрийн хоолны дараа Халонг булангаасаа Ханой хот руугаа буцна. Ханойд ирээд шинээр нээгдсэн Лотте Вэст Лэйк худалдааны төв орно. Оройн хоолны дараагаар Далайн эргийн үзэсгэлэнт Дананг хотруу ниснэ. Дананг хотод буугаад буудалдаа байрлан амарна.



ӨДӨР 4 : БА НА ХИЛЛС – АЛТАН ГҮҮР – ФРАНЦ ТОСГОН – ФАНТАЗИ ПАРК

Зочид буудалдаа өглөөний цайгаа ууна. **Ба На Хиллс** руу хөдөлнө. Далайн түвшнээс 1,500 метрийн өндөрт орших энэ бүс нутаг нь хөл доорх нутгаас 6-8 градусаар сэрүүн, таатай уур амьсгалтай. 20-р зууны эхэн үед Францын амралтын газар байсан бөгөөд өнөөдөр аялал жуулчлалын томоохон бүс болон хөгжсөн. Том Буддагийн хөшөө, сүм хийдүүд, Францын хуучин дарсны зоорь, доторх зугаа цэнгэлийн газрууд, цайз хэлбэрийн амралтын бүс зэрэг олон байгууламжтай. Дэлхийн хамгийн өндөрт байрлах **агаарын дүүжин** шатаар уулын орой руу өгсөнө.

- **Алтан гүүр дээр зочилно.** Асар том гарын дүрстэй тулгуур баганатай, тэнгэрээс бууж ирсэн бурхны мутар мэт харагдах энэ гүүр нь Ба На Хиллсийн хамгийн үзэсгэлэнтэй газруудын нэг. Эндээс уулын гайхамшигт үзэмжийг харангаа зургаа авхуулж, гүүрэн дээгүүр зугаалах боломжтой.
- **Францын тосгон** - Парисын хэв маягийн барилгууд, чулуугаар бүрсэн гудамжнууд нь танд Европт ирсэн мэт мэдрэмж төрүүлнэ. Сэрүүн агаарт тухлан, үзэмжит газруудад зургаа авхуулах сайхан боломж.

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье

- **Фантази парк** - Вьетнамын хамгийн том доторх зугаа цэнгэлийн парк. Энэ парк нь хүүхэд, насанд хүрэгчдэд зориулсан тоглоомуудаас гадна 4D, 5D кино театр зэрэг орчин үеийн үзвэр үйлчилгээтэй. Оройн хоолны дараа зочид буудал руугаа буцаж амарна.



ӨДӨР 5: ДАНАНГ – ВИНВОНДЕР - ХОЙ АН ХОТЫН АЯЛАЛ

Өглөөний цайны дараа Вьетнамын хамгийн том зугаа цэнгэлийн парк Винвондэр орно. Энд та олон төрлийн тоглоом, усан парк, амьтны хүрээлэн гэх мэт сонирхолтой үзвэр үйлчилгээнд хамрагдаж цагийг зугаатай өнгөрүүлнэ. Мөн Вьетнамын анхны голын Сафари аялал буюу (Vinpearl River Safari) -аар завьтай аялж амьтадыг илүү ойроос мэдэрнэ. Дараагаар нь Вьетнамын түүхийг өгүүлэх эртний хот Хой ан тосгон руу аялна. Энэ хот нь 16-19р зуунд зүүн өмнөд Азийн хамгийн том худалдааны боомт байсан бөгөөд эртний Вьетнамын үзэмж, хэв маяг тод томруунаар үлдсэн ЮНЕСКО-оос дэлхийн соёлын өвд бүртгэгдсэн газар болно. Оройн хоолоо орон нутгийн ресторанд идээд Дананг руу буцаж буудалдаа байрлан амарна.



Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

ӨДӨР 6: ДАНАНГ ЧӨЛӨӨТ ӨДӨР

Өглөөний цайгаа уугаад зочид чөлөөт өдөр тул цагийг хүссэнээрээ өнгөрүүлээрэй.



ӨДӨР 7: ДАНАНГ - ХАНОЙ

Өглөөний цайны дараагаар буудлаа хүлээлгэн өгөөд Дананг хотоос Ханой хотын чиглэлд ниснэ. Ханой хотод буугаад чөлөөт цагтай тул та хүссэнээрээ өнгөрөөх боломжтой. Томоохон молл, худалдааны төвүүдээр явж худалдаа хийх боломжтой.



ӨДӨР 8: ХАНОЙ - УЛААНБААТАР

Өглөөний цайгаа уугаад зочид буудлаа хүлээлгэн өгч ачаа тээшээ аван нисэх буудал ороод **13:00-19:00** шууд нислэгээр Монгол буцаж бидний аялал өндөрлөнө.

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!

 AIRPLANE - Аялъя, Хөгжье

Аяллын хөтөлбөр	Том хүн	2-12 нас хүүхэд ор эзлэхгүй	Аяллын өдөр
Хөтөлбөртэй аялал	4,690,000₮	4,290,0000	7/02-09 7/16-23 7/30-8/6 8/06-8/13

АЯЛЛЫН ҮНЭД БАГТСАН ЗҮЙЛС:

- ✓ Улаанбаатар -Ханой-Улаанбаатар шууд нислэгийн тийз
- ✓ Ханой-Дананг-Ханой орон нутгийн нислэгийн тийз
- ✓ Зочид буудлын стандарт твин өрөө /1өрөөнд 2том хүн орно, хүүхэд оргүй/
- ✓ Зочид буудлын буффет өглөөний цай
- ✓ Хөтөлбөр тусгагдсан өдөр болон оройн хоол
- ✓ Хөтөлбөрт тусгагдсан үзвэр үйлчилгээний тасалбар
- ✓ Гадаадад зорчигчийн иж бүрэн даатгал
- ✓ Дата биет сим карт

АЯЛЛЫН ҮНЭД БАГТААГҮЙ ЗҮЙЛС:

- ✓ Хувийн хэрэглээний зардал
- ✓ Нэмэлт үзвэр үйлчилгээний зардал
- ✓ Чөлөөт өдрийн хөтчийн зардал
- ✓ Хөтөлбөрт тусгагдаагүй өдөр болон оройн хоол
- ✓ Нутгийн хөтөч болон жолоочийн гарын мөнгө

Дэлхийгээр тойрон аялж хамгийн сайхан дурсамжийг бүтээцгээе!